

шат дараатай шийдвэрлэн ажиллаж байна.

Цаашид Боомт хот болохоор төлөвлөн ажиллаж байна.



4. ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР НӨХЦӨЛ БОЛОМЖ ОЛГОХ ВЭ?

Газар тариаланд туслах хөдөлмөр эрхлэх, хөдөөгийн 3 дугаар багт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой.

Хөдөө аж ахуйн мэргэжилтэн нэн шаардлагатай. Малын их эмч, агрономич, малын асаргаа сувилгааны ажилтан, өрхийн хашааны тохижилт, интерьер дизайны чиглэлийн аж ахуйн нэгж, хоршоо үүсгэх боломжтой.

Худалдаа арилжаа наймаа эрхлэх нөхцөл бүрэн бүрдсэн. Жижиг дунд бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Суурьшин ирж байгаа иргэдийн хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулах боломжтой. Сумын хэмжээнд 3 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба сургууль цэцэрлэгийн хүрэлцээ хангамж сайн.

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 110 тогтоолоор 2024 онд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2 байршилд 256 иргэнд газар өмчлүүлэхээр төлөвлөсөн.



Алтанбулаг сум



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ

“СЭЛЭНГИЙН ИРЭЭДҮЙ- ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ”

1. СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ

Алтанбулаг сум нь 1729 оны эхээр “Жургааны занги” нэртэйгээр хилийн худалдааг зохицуулах худалдаачдыг баримтлан захирах газар гэж байгуулагдсанаар тус сумын эх үүсвэр тавигдсан. Хожмоо 1778 оноос Наймаачин хот буюу Хиагт хот гэж нэрлэгдэх болсон. 1921 оны Ардын хувьсгалын өлгий болсон Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум нь Улаанбаатар хотоос 345 км, аймгийн төвөөс 25 км зайд баруун талаараа Сүхбаатар, зүүн талаараа Хүдэр, урд талаараа Ерөө, Шаамар сумуудтай хойд талаараа Оросын холбооны улстай хиллэн оршдог.



86615558



<http://altanbulag.se.gov.mn//>



Монгол улсын хойд хил, Худалдааны чөлөөт бүстэй, Хилийн бүс нутаг.

Сумын газар нутаг дээгүүр ОХУ-ыг Нийслэл Улаанбаатар хоттой холбосон улсын чанартай авто зам дайран өнгөрдөг.

Алтанбулаг сум нь нийт 210,030 га нутаг дэвсгэртэй. Засаг захиргааны 3 баг, 1301 өрхөд 4680 хүн амьдардаг.

Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 110/35/10кв-ын дэд станцтай.

Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 25000 м3 багтаамжтай 1 усан санд гүний худагас усыг татан түгээж байна.



Тужийн нарс, ойн эко цамхаг, Ивцэг, Цөх гол, Сайхны хөтөл, Ханын хөндий, Хоёр элс, Гав хад, Гүн нуур, Хонд гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай.

Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ хөгжих бүрэн боломжтой. Байгалийн таатай нөхцөл, авто тээврийн зам харилцаа сайн, хилийн боомт, Алтанбулаг чөлөөт бүс ажилладаг, дэд давуу талтай.

2. ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ

Стандартын шаардлага хангасан үйлчилгээний байгууллагууд болох зочид буудал, зоогийн газар, кафе, явуулын хоолны цэг, байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэсэн халуун хүйтэн ус, боловсон нийтийн бие засах газартай, чанартай үйлчилгээтэй амралтын газрууд шинээр байгуулан ажиллах бүрэн боломжтой нь сумын хөгжлийн онцлог.

Хоёрдогч түүхий эд боловсруулах, хаягдал дугуй боловсруулах үйлдвэр барих боломжтой.

Малын арьс, шир боловсруулах цех, ногоо тарих даршлах бусад үйлдвэрлэл явуулах боломжтой.

Улсын хэмжээнд борлуулалт хийдэг *Ногоон нарс* ХХК панерын үйлдвэр ажилладаг.

3. ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БАЙГАА ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ЦААШИД ХИЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл 2019-2024 он

Сумын хотын хөгжлийн төлөвлөгөө 2023-2024 он

Жишиг сум төсөл 2023-2026 он

Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамж сайжруулах төсөл 2022-2024 он

Тус суманд хэрэгжиж буй “Жишиг сум” төслийн хүрээнд 7 МВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилгын ажлын гүйцэтгэл, усан халаалтын зуухны тоног төхөөрөмжийн суурилуулалт, барилгын ажил хийгдэж байна.



Улсын төсвийн 650.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бохирын шугамын засварын ажил хийгдэж, сумын “Цэвэрлэх байгууламж” бүрэн ашиглалтад орсон.

Сумын төв доторх 3.6 км сайжруулсан замыг хатуу хучилттай зам болгохоор төсвийг

